



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

“Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.13, 63.1.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 55.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

00001

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**



**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмаар хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нөхцөл, тавигдах шаардлага, сангийн хөрөнгөөр үнэт цаас болон бусад зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгслэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, хадгалах, бүртгэх, хяналт тавих, хөрөнгө оруулалтын менежментийн гэрээ болон хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан журмын дагуу зөвхөн Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэнэ.

1.3. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих үйл ажиллагааны онцлогтой холбоотой нийтлэг харилцааг Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар, нарийвчилсан харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаа энэхүү журмаар зохицуулагдахгүй.

1.5. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1. “хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33 болон 40.1-д заасан үйл ажиллагааг;

1.5.2. “кастодианы үйл ажиллагаа эрхлэгч” гэж Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4.1.12-д заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

**Хоёр. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх  
этгээдэд тавигдах шаардлага**

2.1. Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон энэхүү журамд заасан шаардлага хангасан хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компанид олгоно.

2.2. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компани /цаашид “хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэх/ нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. Компанийн тухай хуульд заасан компанийн хэлбэртэй;

2.2.2 Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын санг удирдах болон үнэт цаасыг итгэмжлэлээр удирдах үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагааг эрхэлдэггүй;

2.2.3. Үүсгэн байгуулагч-хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд кастодиан, гэрээт үнэлгээчин болон аудитор байхгүй;

2.2.4. Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн дарга, гишүүнд дараах шаардлага тавигдана:

2.2.4.1. санхүүгийн зах зээл дээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай, энэ чиглэлээр мэргэшсэн байх;

2.2.4.2. энэ журмын 2.2.6.1-т заасан компанид зөрчлийн улмаас тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үед удирдлагад нь ажиллаж байсан бөгөөд тусгай зөвшөөрөл хүчингүй болсноос хойш 3 жил өнгөрсөн байх;

2.2.4.3. санхүү, үнэт цаасны зах зээлд гаргасан зөрчлийн улмаас захиргааны хариуцлага хүлээснээс хойш 1 жил өнгөрсөн байх;

2.2.4.4. хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэртэй өр төлбөргүй байх;

2.2.4.5. эдийн засаг, санхүүгийн эсрэг гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэлээр шийтгүүлж байгаагүй байх.

2.2.5. Менежментийн компани нь 3-аас доошгүй гишүүнтэй ТУЗ-тэй байх бөгөөд тэдгээрийн олонхи нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан этгээд байна;

2.2.5.1. тухайн компани болон түүний холбогдох этгээдэд ажил албан тушаал эрхлэдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд эрхлэж байгаагүй;

2.2.5.2. бизнесийн харилцаатай компанийн толгой эсхүл охин, хараат компанийн ажилтан, албан тушаалтан биш байх;

2.2.5.3. компанийн дүрмээр тогтоосон бусад шаардлага.

2.2.6. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн ТУЗ-ийн дарга, гишүүнээс бусад гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь дараах шаардлагыг хангасан байна;

2.2.6.1. үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

2.2.6.2. гадаадын эсхүл өөрийн орны санхүүгийн зах зээлд 3-аас доошгүй жил хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах түвшний албан тушаал эрхэлж байсан;

2.2.6.3. дараах чиглэлээр 2-оос доошгүй кредитийн үнэлгээтэй курсд гадаад улсад эсхүл Монгол улсад суралцсан, санхүү эдийн засгийн чиглэлээр бакалавраас доошгүй боловсролын зэрэгтэй эсхүл олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч (CFA)-ын 2 дахь зэрэг /level 2/-ээс доошгүй байх:

2.2.6.3.1. тоон шинжилгээний арга;

2.2.6.3.2. макро, микро эдийн засгийн онол, санхүүгийн тайлагнал;

2.2.6.3.3. санхүүгийн тайлангийн дүн шинжилгээ, компанийн /корпорац/ санхүү;

2.2.6.3.4. хөрөнгө оруулалтын шинжилгээ, портфелийн менежмент, төслийн үнэлгээ;

2.2.6.3.5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-д заасан мэргэжлийн холбооноос үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллах эрх авсан байх.

2.2.6.4. тухайн компанитай гэрээгээр ажилладаг кастодиан, үнэлгээний болон аудитийн компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээчин, аудиторын холбогдох этгээд биш байх;

2.2.7. Менежментийн компани нь ТУЗ-аас томилогдсон 3-аас доошгүй гишүүнтэй дотоод хяналтын албатай байх бөгөөд гишүүдийн 1-ээс доошгүй нь аудитын үйл ажиллагаа явуулах эрх авсан, энэ чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан этгээд байна;

2.2.8. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 100 сая төгрөг байх;

2.2.9. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдаж буй хөрөнгө оруулалтын сангууд нь хууль болон Хорооноос тогтоосон активийн бүтэц, бүрэлдэхүүний шаардлагыг хангасан байна;

2.2.10. Удирдаж байгаа сангуудийнхаа цэвэр актив болон активийн цэвэр өртгийг Хорооноос тогтоосон хугацаанд тодорхойлж байх;

2.2.11. Хууль болон Хорооноос тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгох, хэвлэн нийтлэх үүргээ биелүүлж, эрх бүхий этгээдийн шаардлагаар гаргаж өгөх мэдээллийг хугацаанд нь тогтоосон арга хэлбэрээр мэдээлж байгаа;

2.2.12. Удирдаж буй хөрөнгө оруулалтын сангаас цөөнгүй тооны эрх бүхий менежертэй, өөр албан тушаалд хавсран ажилладаггүй дотоод хяналтын ажилтантай байна.

### **Гурав. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, хавсаргах баримт, материал**

3.1. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ.

3.1.1. энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргасан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

3.1.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.1.3. компанийн эрх бүхий байгууллагаас гаргасан хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх талаарх шийдвэр;

3.1.4. компанийн дүрэм;

3.1.5. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасныг болон үүсгэн байгуулагчдаас оруулсан хөрөнгө нь хууль ёсны орлого болохыг нотлох баримт, үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд бол сүүлийн 3 жилийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, татвар төлөгчийг тодорхойлох баримт;

3.1.6. тухайн компанийн нийт хувьцааны 1 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

3.1.7. компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, менежерүүд болон үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулах мэргэжилтний дэлгэрэнгүй мэдээллийг дараах хэлбэрээр ирүүлнэ:

3.1.7.1. энэхүү журмын хавсралт 2-оор гаргасан дэлгэрэнгүй анкет;

3.1.7.2 гүйцэтгэх удирдлага, менежерүүд болон үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулах мэргэжилтнүүдийн үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ эрхлэх эрхийн үнэмлэхийн хуулбар;

3.1.7.3 тэдгээр нь гэмт хэрэгт холбогдож, ял шийтгэгдэж байгаагүй талаар цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

3.1.7.4 санхүүгийн байгууллагад ажиллаж байхдаа сүүлийн 1 жилийн хугацаанд захиргааны хариуцлага хүлээж байгаагүй, мөн зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашиж байгаагүй талаар Монголбанк, Хорооны холбогдох газрын тодорхойлолт;

3.1.8. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүд, үндсэн үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх ажилтнууд нь энэ журмын 2.2-т заасан шаардлагыг хангаж байгаа тухай тэдгээр этгээдийн өөрсдийн гараар бичиж нотариатаар баталгаажуулсан тодорхойлолт, холбогдох диплом, сертификатын хуулбар,

3.1.9. ажлын байр, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл, өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээ, тоног төхөөрөмж болон програмын тодорхойлолт;

3.2. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь дараах журмуудыг боловсруулан нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаар баталсан байна:

3.2.1. хөрөнгө оруулалтын компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;

3.2.2. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн дотоод хяналтын журам;

#### **Дөрөв. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, бичиг баримтыг хүлээн авах, тусгай зөвшөөрөл олгох**

4.1. Хороо хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт, холбогдох баримт, материалыг 30 хоногийн дотор хянана.

4.2. Энэхүү журмын 4.1-д заасан хугацааг тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагыг хангаж ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

4.3. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 10 хүртэл жилийн хугацаатайгаар олгоно.

4.4. Хорооноос хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хянах, тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах, олгох, түдгэлзүүлэх, хувь нийлүүлсэн хөрөнгийг тодорхой дансанд байршуулахыг шаардах, тусгай зөвшөөрлийн нэгдсэн бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5, 6 дугаар зүйлээр зохицуулна.

4.5. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн материалыг Хорооны даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хянаж, санал бэлтгэн Хорооны хуралдаанд танилцуулна. Уг ажлын хэсгийг Хорооны ажлын албаны дарга ахална.

4.6. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь зөвхөн энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх бөгөөд бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

#### **Тав. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа, гүйцэтгэх үүрэг**

5.1. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.1-г зааснаар Хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсанаар хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулж болно.

5.2. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулсанаар тухайн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг удирдах-хадгалуулах үүргийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

5.3. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь удирдаж буй хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг зөвхөн кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хадгалуулна.

5.4. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын санд холбогдох үйлчилгээг үзүүлэхдээ тухайн сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.

5.5. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.5.1. удирдаж буй хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хадгалуулах;

5.5.2. сангийн хөрөнгө, тэдгээрийг шилжүүлэхтэй холбогдсон анхан шатны баримтыг үйлдсэн болон хүлээн авсан даруйдаа тэдгээрийн хувийг кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд хүргүүлэх;

5.5.3. Хорооноос тогтоосон мэдээ, тайланг тогтоосон хэлбэрээр, хугацаанд нь гаргаж өгөх;

5.5.4. Хорооноос тогтоосон журмын дагуу хөрөнгө оруулалтын сангийн мэдээллийг нийтийн хүртээл болгох, сонирхсон этгээдэд өгөх;

5.5.5. Хорооны зөвшөөрөлгүй өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн болон гүйцэтгэх удирдлага, сангийн менежерийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй байх;

5.5.6. Хорооны зөвшөөрөлгүй салбар, төлөөлөгчийн газар нээхгүй байх,

5.5.7. Хорооноос өгсөн үүрэг даалгаварыг тухай бүр биелүүлж ажиллах.

5.6. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхээс татгалзах эрхтэй.

5.7. Энэ журмын 5.6-д зааснаар татгалзах бол энэ тухай ажлын 3 хоногт багтаан хөрөнгө оруулалтын сангийн удирдах зөвлөл болон Хороонд бичгээр мэдэгдэнэ.

5.8. Хөрөнгө оруулалтын сангийн ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй бол дараагийн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай гэрээ байгуулах хүртэл тухайн хөрөнгө оруулалтын менежментийн компани үүргээ хэрэгжүүлнэ.

5.9. Энэхүү журмын 5.8-д заасан хөрөнгө оруулалтын менежментийн компани хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө, бичиг, баримтыг шинээр томилогдсон хөрөнгө оруулалтын менежментийн компанид шилжүүлнэ.

5.10. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйлчилгээний хөлс, урамшуулалыг хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөс төлөх бөгөөд уг харилцааг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр зохицуулах боловч энэ нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 28.1, 28.3-т заасан хүрээнд зохицуулагдана.

#### **Зургаа. Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ**

6.1. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын сан, харилцагчийн үнэт цаас, мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ /цаашид “хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ” гэх/ байгуулж, холбогдох үйлчилгээг үзүүлнэ.

6.2. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь энэхүү журмын 6.1-д заасан гэрээ байгуулалгүйгээр харилцагчид аливаа хөрөнгө оруулалтын сан болон бусад этгээдэд хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

6.3. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь харилцагчтай энэхүү журмын 6.1-д заасан гэрээг байгуулахад түүнд хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг танилцуулах үүрэгтэй.

6.4. Энэхүү журмын 6.1-д заасан гэрээнд талууд хууль тогтоомжоор хориглоогүй, энэхүү журмын 6.5-д зааснаас бусад зүйлийг чөлөөтэй тусгаж болно.

6.5. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд дараах зүйлийг тусгана:

- 6.5.1. үзүүлж буй үйлчилгээний төрөл, хэлбэр;
- 6.5.2. итгэмжлэлийн хөрөнгө болон үнэт цаасны талаар;
- 6.5.3. талуудын эрх, үүрэг;
- 6.5.4. нэгж эрхийн эзэмшигчдийн хурал,
- 6.5.5. нэгж эрхийг эргүүлэн худалдаж авах
- 6.5.6. хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн төрөл болон хэмжээ
- 6.5.7. үйлчилгээний төлбөр, урамшуулал болон түүнтэй холбоотой бусад мэдээлэл;
- 6.5.8. хөрөнгө итгэмжлэн удирдах хөрөнгийн удирдлага болон хадгалалтын талаар;
- 6.5.9. хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг эзэмшигч-гишүүдэд хүргэх мэдээллийн төрөл, мэдээлэл хүргэх хэлбэр, давтамж;
- 6.5.10. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн санхүү, тооцоо, бүртгэлийн талаар;
- 6.5.11. гэрээг цуцлах үндэслэл, журам;
- 6.5.12. давтагдашгүй хүчин зүйл (форс-мажор)-ийн нөхцөлүүд;
- 6.5.13. хэрэглэх хууль тогтоомжийн хүрээ болон маргаан шийдвэрлэх журам;
- 6.5.14. хууль тогтоомжоор хориглоогүй шаардлагатай бусад.

6.6. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх, түүгээр гүйцэтгүүлэхийг хориглоно.

6.7. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд талууд хэдийд ч өөрчлөлт оруулж болох боловч хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрөөр заагаагүй бол дараах асуудлаар зөвхөн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч-гишүүдийн хурлын шийдвэрээр өөрчлөлт оруулна.

- 6.7.1. хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний хөлс, урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх;
- 6.7.2. хөрөнгө итгэмжлэн удирдах хугацаанд өөрчлөлт орох;
- 6.7.3. нэгж эрх эзэмшигч, харилцагчдын хүртэх ашгийн хэмжээнд өөрчлөлт оруулах;

6.8. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд орсон өөрчлөлтийг ажлын 3 өдрийн дотор Хороо болон хөрөнгө оруулалтын сангийн гишүүдэд мэдээлнэ.

#### **Долоо. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаанд хориглох зүйлс**

7.1. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагаанаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- 7.1.1. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөр тухайн хөрөнгийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогод хамааралгүй хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;
- 7.1.2. хорооноос тогтоосон хэм хэмжээ, шалгуур үзүүлэлт зөрчигдөхөд хүргэх хэлцэл хийх;
- 7.1.3. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг аливаа хэлбэрээр үнэ төлбөргүй шилжүүлэх;

- 7.1.4. тухайн үед хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөнд шилжээгүй байгаа хөрөнгийг шилжүүлэх үүрэг хүлээсэн хэлцэл хийх;
- 7.1.5. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг барьцаалан зээл авах.
- 7.1.6. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөс бусдад зээл олгох;
- 7.1.7. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг өөрийн болон гуравдах этгээдийн өр төлбөрийг төлөх барьцаа, баталгаа болгон ашиглах;
- 7.1.8. хөрөнгө оруулалтын менежментийн компани нь үүсгэн байгуулсан хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөр хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдан авах;
- 7.1.9. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын бодлогод заасан хэмжээнээс илүү хэмжээний санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах;
- 7.1.10. 2-оос дээш тооны хөрөнгө оруулалтын санг удирдаж байгаа бол өөрийн удирдлагад байгаа нэг сангийн хөрөнгөөр нөгөөд хөрөнгө оруулалт хийх, нэгж эрхийг худалдах, худалдан авах;
- 7.1.11. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг өөртөө аливаа хэлбэрээр шилжүүлэн авах;
- 7.1.12. хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний хөлс, урамшууллаас бусад хэлбэрээр хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг шилжүүлэн авах;
- 7.1.13. өөрийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын санд шилжүүлэх;
- 7.1.14. хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр хүлээсэн үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, бусдаар гүйцэтгүүлэх;
- 7.1.15. удирдаж буй хөрөнгө оруулалтын сан, тухайн санд кастодианы болон бусад үйлчилгээ үзүүлж буй компани, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаасыг хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөр худалдан авах;
- 7.1.16. өөрөө удирдаж байгаа хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдан авах.
- 7.1.17. хөрөнгө оруулалтын санг удирдах болон үнэт цаасыг итгэмжлэлээр удирдах үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагааг эрхлэх.

7.2. Хөрөнгө оруулалтын сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.9-д зааснаар үүсмэл санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болох бөгөөд энэ тохиолдолд оруулах нийт дүн нь хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй байна.

#### **Найм. Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хадгалах, зарцуулалтад тавих хяналт**

- 8.1. Хөрөнгө оруулалтын сангийн гаргасан нэгж эрхийг зөвхөн кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эрхлэгч этгээдэд бүртгэж, хадгалах бөгөөд хөрөнгө оруулалтын сангийн мөнгөн хөрөнгө болон сангийн актив дахь хөрөнгө оруулалтын хэрэгслийг кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тухайн сангийн нэр дээр нээсэн дансанд байршуулна.
- 8.2. Нэг хөрөнгө оруулалтын сангийн гаргасан нэгж эрхийг бүртгэх, хадгалах үйл ажиллагааг зөвхөн нэг кастодиан гүйцэтгэнэ.
- 8.3. Хөрөнгө оруулалтын сангийн эзэмшилд байгаа үнэт цаасыг кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд түүний нэр дээр тусдаа дансанд бүртгэнэ.
- 8.4. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн Хорооноос тогтоосон журам заавар, сангийн дүрэм, сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан болон хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн



хэрэгжүүлж байгаад сангийн хөрөнгийг гэрээгээр хадгалж байгаа кастодиан нь хяналт тавина.

8.5. Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг шилжүүлэх, аливаа бусад хэлбэрээр захиран зарцуулах нь хууль тогтоомж, Хорооноос тогтоосон журам заавар, сангийн дүрэм хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, болон хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээ, хамтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах журмыг зөрчихөөр байгаа тохиолдолд кастодиан нь хөрөнгө оруулалтын менежментийн компанид сангийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөл олгохыг хориглох эрхтэй.

8.6. Энэ журмын 8.4, 8.5-д заасан үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь сангийн оролцогчдын өмнө сангийн менежертэй хамт хариуцлага хүлээнэ.

### **Ес. Хариуцлага**

9.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан захиргааны хариуцлагыг Хорооны хянан шалгагч-улсын байцаагч ногдуулна.

9.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт, зөрчилд энэ журмаар хариуцлага ногдуулахгүй.

9.3. Энэ журмын 1-д заасан захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар тогтоолоор баталсан  
 “Хөрөнгө оруулалтын менежментийн тусгай зөвшөөрлийн  
 болон үйл ажиллагаа эрхлэх тухай журам”-ын 1 дүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо : .....  
 Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,  
 Засгийн газрын IV байр  
 Бага тойруу -6  
 Улаанбаатар -210646  
 Монгол улс.

Хэнээс: .....  
 .....  
 .....

(*өргөдөл гаргагчийн овог, нэр, эрхэлж буй албан тушаал, хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг*)

.....  
 Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн нэр/ ХХК

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн:

№	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар /Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/	Хаяг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувь (мянган .төгрөгөөр)

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/..... / /..... /  
 /гарын үсэг/ /овог, нэр /

/..... / / албан тушаал /

/тамга тэмдэг/

*Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар тогтоолоор баталсан  
“Хөрөнгө оруулалтын менежментийн тусгай зөвшөөрлийн  
болон үйл ажиллагаа эрхлэх тухай журам”-ын 2 дугаар хавсралт*

Компанийн эрх бүхий албан тушаалтан нь /гүйцэтгэх захирал, сангийн менежер, ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын ажилтнууд/ дараах хүмүүс болно. Үүнд:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Мэргэжлийн байгууллагад эрхлэх албан тушаал

Компанийн үндсэн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх мэргэжилтнүүд нь дараах хүмүүс болно

№	Овог, нэр	Регистрийн болон иргэний үнэмлэхийн дугаар	Гэрийн хаяг	Тухайн ажил үйлчилгээг эрхэлсэн хугацаа	Албан тушаал	Тухайн ажил үйлчилгээг эрхлэх эрхийн үнэмлэхийн дугаар

Бүртгүүлэхээр хүргүүлсэн баримтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны ... дүгээр сарын ...-ний өдрийн .. дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн бичиг баримтад аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан шалгаж, хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу?

Бид үйл ажиллагаандаа Иргэний хууль, Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж байх болно.

/...../

*/гарын үсэг/*

/...../

*/овог, нэр/*

/...../

*/ албан тушаал /*

*/тамга тэмдэг/*